



ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.4, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албаны хэрэгцээнд ашиглах "Гар утас болон үүрэн телефоны дугаар ашиглах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2014 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөн ажиллахыг аймаг, нийслэлийн Шийдвэр гүйцэтгэх албадын дарга нарт үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шийдвэр гүйцэтгэх газрын Мэргэжлийн удирдлагын хэлтэс /дэд хурандаа Б.Батболд/-т даалгасугай.

ДАРГА, ХУРАНДАА



Д.ЯДАМДОРЖ

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2014 оны 4 дугаар тушаалын хавсралт



## ГАР УТАС БОЛОН ҮҮРЭН ТЕЛЕФОНЫ ДУГААР АШИГЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Том төрөөс ухаалаг төр лүү” үндэсний уулзалтын шийдвэрийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангах, иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдлыг бууруулах, тэдний санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, шийдвэр гүйцэтгэгч нарын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх үүднээс гар утас болон үүрэн телефоны дугаар ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

### Хоёр. Гар утас болон үүрэн телефоны дугаар олгох

2.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагч, аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албадын дарга, ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгч нарын албан хэрэгцээнд үүрэн телефоны дугаар олгох бөгөөд тухайн дугаар Шийдвэр гүйцэтгэх байгууллагын эзэмшилд байна.

2.2. Дор дурдсан албан хаагчид энэ журамд хамрагдана.

2.2.1. Шийдвэр гүйцэтгэх газрын дарга;

2.2.2. Мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга;

2.2.3. Мэдээлэл, лавлагаа, тоо бүртгэлийн тасгийн дарга;

2.2.4. Шийдвэр гүйцэтгэх газрын ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн,

2.2.5. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албадын дарга;

2.2.6. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албадын ахлах шийдвэр гүйцэтгэгч;

2.2.7. Аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албадын шийдвэр гүйцэтгэгч;

2.3. Гар утас болон үүрэн телефоны дугаарыг ашиглаж буй албан хаагч өөр ажилд шилжсэн, чөлөөлөгдсөн, халагдсан тохиолдолд тухайн албанд бүрэн бүтэн, төлбөрийн тооцоогүй хүлээлгэн өгнө.

### Гурав. Гар утас болон үүрэн телефоны дугаар ашиглах

3.1. Албан хэрэгцээнд олгогдсон гар утсыг 24 цагийн турш нээлттэй байлгана.

3.2. Албаны хэрэгцээнд олгогдсон үүрэн телефоны дугаарт ирсэн дуудлага бүрийг хүлээн авч хариу өгнө.

3.3. Дуудлага хүлээн авах боломжгүй бол дуудлага хийх боломжтой болсон даруйд хүлээн аваагүй дугаарт нэн даруй эргэн холбогдоно.

3.4. Алба хаагч албаны хэрэгцээнд олгогдсон гар утасны хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдал, үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд тухайн алба хаагч бүрэн хариуцна.

3.5. Үүрэн телефоны сүлжээний хамрах хүрээнээс гарсан, утасны цэнэг дууссан тохиолдолд дээд шатны албан тушаалтанд, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны томилолтоор явах үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шуурхай удирдлагын төвд мэдэгдэнэ.

### **Дөрөв. Гар утас болон үүрэн телефоны дугаар ашигласны төлбөр**

4.1. Албан хэрэгцээнд олгогдож буй үүрэн телефоны дугаар Шийдвэр гүйцэтгэх газар, нийслэлд 40.000 төгрөг болон орон нутаг дахь шийдвэр гүйцэтгэх алба, хэсэгт 30.000 төгрөгийн үйлчилгээний эрхтэй байна.

4.2. Шийдвэр гүйцэтгэх албад үйлчилгээний төлбөрийг сар бүр үйл ажиллагааны зардлаас тухайн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, санхүүгийн ажилтан гэрээнд заасны дагуу шилжүүлнэ.

4.3. Шийдвэр гүйцэтгэх газрын алба хаагчдын үйлчилгээний төлбөрийг холбогдох зардлаас гаргана.

4.4. Энэ журмын 4.1-д заасан багцаас хэтэрсэн үйлчилгээний төлбөрийг тухайн алба хаагч хариуцна.

4.5. Үйлчилгээний багцаас хэтэрсэн үйлчилгээний төлбөрийг төлөөгүй тохиолдолд алба хаагчийн цалингаас суутгах үндэслэл болно.

### **Тав. Хориглох зүйл**

5.1. Албаны хэрэгцээнд олгогдсон үүрэн телефоны дугаарт ирсэн дуудлагыг хүндэтгэн үзэх шалгаангүйгээр аваагүй, эргэж холбогдоогүй, гар утсыг салгасан, гаднаас ирэх дугаарыг хязгаарласан, утсаар харилцахдаа ёс зүй, зан харилцааны зөрчил дутагдал гаргах, хувийн чанартай зар өгөхийг хориглоно.

### **Зургаа. Хариуцлага**

6.1 Энэ журмын 5.1 дэх заалтыг зөрчсөн алба хаагчид Төрийн албаны тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны ёс зүйн дүрэмд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---- ооОоо ---